

“ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ АЖИЛ-БИДНИЙ СУУРЬ ЭРХ” УРИАТАЙ ХАБЭА-Н САРЫН АЯНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2023.05.04

Хэрлэн сум

“Эрүүл аюулгүй ажил-бидний суурь эрх” уриатай ХАБЭА-н сарын аяны хүрээнд “ДБЭХС” ТӨХК дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.


1. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр хийсэн ажил:

ДБЭХС ТӨХК-ийн ҮЭ-ийн хорооноос жил бүр зохион байгуулагддаг ашиглалтын нэгдсэн ээлжүүдийн, засварын бригадуудын, инженер техникийн ажилтнуудын “Цехийн дарга нарын нэрэмжит” спортын олон төрөлт тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа.





ХАБЭА-н тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу 2023 оны нийт ажилтны урьдчилан сэргийлэх хугацаат үзлэг 4 сарын 10-аас 22-ны хооронд хийгдлээ. Үзлэгээр лабораторийн шинжилгээ, багажийн буюу дотор эрхтэний ЭХО болон цээжний рентген оношилгоо, чих хамар хоолойн эмчийн үзлэг, нүдний эмчийн үзлэг, арьс харшлын эмчийн үзлэг, зүрхний цахилгаан бичлэг, дотор зүрх судасны эмчийн үзлэг хийгдсэн.





2. Сургалт сурталчилгааны ажил

Компанийн өргөх зөөх механизмуудын операторууд, механизмын бүрэн бүтэн байдал хариуцагчид, аюулгүй ажиллагаа хариуцагчид болон оосорлогч дохиочин нарт эрх олгох сунгах сургалтыг зохион байгуулав. Мэргэжлийн байгууллагаар тусгай тоноглолын 7 автомашинд ээлжит магадлагаа хийлгэв.



ХАБЭА-н сарын аянтай холбоотой Дорнод аймгийн ХАБЭА-н зөвлөлөөс зохион байгуулсан өдөрлөг арга хэмжээнд оролцлоо.





Жил бүрийн 4 сарын 28-ыг олон улсын “ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН УЛМААС АМЬ ҮРЭГДСЭН АЖИЛТНУУДЫН ДУРСГАЛЫГ ХҮНДЭТГЭХ ӨДӨР” болгон зарлаж хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай. Энэ өдөр компанийн хэмжээнд үйлдвэрлэлийн ослоор амь үрэгдсэн ажилтнуудад хүндэтгэл үзүүлж нийт ажлын байруудад зул мандаалаа. Үйлдвэр дэх мэдээллийн урсдаг самбарт ослоос урьдчилан сэргийлэх талаар санамж мэдээлэл байршуулав. Мөн амь үрэгдсэн 2 ажилтны ар гэрт мөнгөн тусламж үзүүллээ. Манай компанийн хэмжээнд 1971 оноос хойш нийт 114 үйлдвэрлэлийн осол бүртгэгдсэнээс 8 хүн амь үрэгдсэн байна.



3. Бусад ажлын хүрээнд

“ДБЭХС” ТӨХК-ийн “Цахилгаан дулааны эрчим хүчээр хангах мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, гамшгаас хамгаалах “Иж бүрэн сургууль”-ийн талаар мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд сургалт явуулав.

